

Соёл судлалын ухаанд өргөн хэрэглэгдэх зарим нэр томъёо, тэдгээрийн тайлбарын орчуулга

Доктор, профессор Т.Дорждагва

1. Адаптация (лат. adaptatio < adaptare - дасан зохицох) нь өөрийн дотоод шинж онцлогийг өөрчлөх замаар нийгмийн тогтолцоонууд хүрээлэлдээ идэвхитэй дасан зохицох үйл явц юм /17/.
2. Аккультурация (англ. acculturation < лат. ad+cultura – боловсрол, хөгжил) нь нэг ард түмний соёл нөгөө ард түмний, тэгэхдээ ихэвчлэн өндөр хөгжилтэй ард түмний соёлыг бүхлээр нь буюу хэсэгчлэн хүлээн авахад хүргэх соёлуудын харилцан нөлөөллийн үйл явцыг тэмдэглэх АНУ-д XX зууны 30-аад онд үүсэж буй болсон угсаатны зүй болон соёл судлалд ашигладаг нэр томъёо болно. Аккультурацийг ассимиляци (уусгах - Т.Д.) болон угсаатны нягтралын үйл явцын олон янз байдал гэж үздэг /18/.
3. Аксиология (грек. axio-үнэлэмж+logos-сургаал) бол хүний хүсэл, эрмэлзлэл, ашиг сонирхолын зүйл болж, хүнд учир холбогдолтой эрхэм буянтай юм, объектуудын тухай нэгтгэн дүгнэсэн тогтвортой төсөөллүүд, үнэлэмжийн тухай философийн сургаал болно /19/.
4. Альтруизм (франц. altruisme, лат. alter-өөр, бусад) нь бие хүн өөр хүн буюу нийгмийн нийтлэгийн ашиг сонирхлын төлөөнөө өөрийн ашиг сонирхлыг харамгүй золиослоход бэлэн байх явдал юм /22/.
5. Антропология культурная (соёлын хүн судлал) нь орчин үеийн этнологи буюу нийгэм-соёлын антропологи буй болох үед үүссэн арга зүйн баримтлал юм. Соёлын хүн судлал үндсэндээ АНУ-дхөгжиж ирсэн бөгөөд түүний эхийг тавигч нь америкийн угсаатан судлаач, хүн судлаач Ф.Боас юм. Нийгмийн хүн судлалаас соёлын хүн судлалын ялгаа нь оюун санааны бүрэлдэлд илүүтэй анхаарч, материаллаг зүйлд болон нийгмийн харилцааны тогтолцоонд багаанхаардаг оршино. Энэ талынхан арга зүйн хувьд историзмд их ач холбогдол өгөх буюу тухайлбал бичиглэх арга барилд сүрхий анхаардаг юм. Соёлын хүн судлалд соёлын хөгжлийн хөдлөл зүйн асуудал, үеэс үед соёл дамжих механизм тэргүүн зэрэгт гарч ирдэг. Соёлын хүн судлал хүй нэгдлийн нийгмийн түүх, газар зүй, технологи зэрэг ухаануудтай их холбогдсон юм. Өнөөдөр нийгмийн болон соёлын хүн судлалууд онол хийгээд арга зүйн утгаар нэгдчихжээ. АНУ-д тэнхим, хичээл, эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны байгууллага, албан газруудын нэр соёлын хүн судлал гэдэг нэр томъёог уламжлал ёсоор хүндэтгэн хэрэглэсээр байна. Соёлын хүн судлал төлөвших үеийг судлаачид угсаатны зүйн (1800-1850), эволюционист (XIX зууны 60-аад он), түүхэн (XIX зууны 90-ээд оноос XX зууны 20-иод оны дундуур) гэж ялгажээ. Цаашдаа бүтэц-функцийн (XX зууны 30-50-иад он), эволюционист бус (XX зууны 60-70-аад он), постструктуралист (XX зууны 80-аад оноос эдүгээ хүртэл) гэж бас ялган үзэж болно /29-30/.
6. Антропоцентризм (грек. anthropos-хүн+centrum-төв) нь хүн бол орчлонгийн төв, ертөнцийн бүхий л барилгын эцсийн зорилго гэж үзэх үзэл юм /31-32/.
7. Архетип (грек. arche – эхлэл + typos – дүр) нь хайр дурлал, хүчирхийлэл, хөдөлмөр, аз жаргал гэхчлэн нийгмийн амьдралын суурь бүтцүүдийг хүртэх ухамсарт бус хэлбэр юм. К.Юнгийн сэтгэл зүйн онолд архетип нь нийт хүн төрөлхтний бэлгэдэл, зүүд, шидэт домог, үлгэр, домог, хууч үг гэх мэтсийн үндсэнд орших хамтын ухамсаргүйн бүтцийн элемент болно /39/.
8. Буддизм нь дэлхийн гурван шашины нэг бөгөөд НТӨ VI-V зуунд Эртний Энэтхэгт үүсчээ. Үндэслэгч нь Сиддхарта Гаутама (НТӨ 623-544) юм. Буддизм Төв болоод Зүүн Өмнөт Азид дэлгэрчээ. Зовлон, түүний шалтгаан, чөлөөлөгдөх байдал болон түүнд хүрэх зам байдаг гэх дөрвөн буянтай үнэний тухай сургаал буддизмын гол төвд оршино. Буддизмд субъект болон объект, оюун ухаан болон материйг эсрэгцүүлэн тавьдаггүй, бүтээгч бөгөөд дээд оршихуй болох бурхан тэнгэр байдаггүй нь сонин бөлгөө /67/.
9. Вера (итгэл бишрэл) нь соёлын түүхэн дэх баталгаагүйгээр магадлалтай хэмээн хүлээн авдаг үйл явдал, онол, тэрчлэн санаанаас буй болсон зүйл (шидэт домог, үлгэр) зэрэгт харьцахуй юм. Итгэл бишрэл дээр шашин үндэслэгддэг (78).

10. Внешняя и внутренняя культура (гадаад ба дотоод соёл) нь аливаа хүний гадаад, дотоод дүр зургийг дүрслэн гаргахад ердийн практикт хэрэглэгддэг нэр томъёо юм /84/.
11. Воспитание (хүмүүжил) нь үйлдвэрлэл, нийгэм болон соёлын үйл ажиллагаанд бие хүнийг бэлтгэх зорилгоор бие хүний оюуны болоод бие бялдрын хөгжилд зорилго чиглэлтэй тогтолцоот байдлаар үйлчлэн нөлөөлөх үйл явц. Хүмүүжил нь боловсрол, сургалттай нягт холбоотой байж, тухайн нийгэм түүхийн холбогдол бүхий хүн төрөлхтөнд хүртээмжтэй соёлын бүх ололтыг бүтээлчээр эзэмших үйл явцад хэрэгжинэ. Хүмүүжил боловсрол болон сургалттай холбоотойгоор сайн, үнэн, сайханд харьцах зэрэг тодорхой үнэлэмжид бие хүнийг зүй тогтлоор чиглүүлэх зан суртахуун, шинжлэх ухаан-танин мэдэхүй болоод уран сайхны соёлыг хувь хүн эзэмших хийгээд хүний тодорхой чанаруудыг өөртөө боловсруулах явдал болно. Хүмүүжлийн зорилго, агуулга, зохион байгуулалт нь нийгмийн ноёлогч харилцаагаар тодорхойлогддог. Түүхэн ёсоор хэд хэдэн хэв маяг байв: •Хүн буй болох зорилт болон гадаад параметрт чиглэгдсэн хэлбэржүүлэгч хэв маяг; •Хүний хэмжүүр өөрт нь байх өөрөө төвт хэв маяг; •Хүмүүсийн харилцаа хэн нэгийг төв гэж илэрхийлэхгүй буюу субъект хоорондын хэв маяг гэж байв /86-87/.
12. "Вторая природа" ("хоёрдогч байгаль") нь соёл судлалд өргөн хэрэглэгддэг нэр томъёо. Хүн төрөлхтөн өөрийн оршихуйдаа байгалийн орчинтой бодис, энерги, мэдээлэл байнга солилцдог. Энэ нь хоёр төрлийн байдаг. Нэгдүгээрх нь хүний физиологийн хэрэгцээг хангах буюу ус, агаар, ургамал, амьтны янз бүрийн зүйлүүд, эрдэс гэх мэт байгалийн нөөцийг шууд ашиглах, хоёрдугаарх байгальтай хүн харьцах материаллаг харилцааны төрөл нь байгаль дээр байдаггүй юмыг хүн бүтээх (хүний) хөдөлмөрийн үйл ажиллагаа юм. Тийм үйл ажиллагаа зөвхөн хүний нийгэмд л зуршмал байдаг аж. Үйл ажиллагааны үр дүн нь байгалийг болон хүнийг өөрийг нь "хүнжүүлэх" явдал юм. Хүний хөдөлмөр хийгээд мэдлэгээр бүтээгдсэн зүйлийг гуманистикт тэмдэглэхдээ "хоёрдогч байгаль"-ийг зүйрлэсэн илэрхийллийг ашигладаг. Орсын зохиолч М.Горький хоёрдогч байгаль нь "үгийн оносон, жинхэнэ утгаараа соёл юм" гэж хэлжээ. Хоёрдогч байгалийн масштаб хүн төрөлхтний түүхэн хөгжилд байнга хэлбэрэлтгүйгээр өсөж байдаг /90/.
13. Гармония (грек. harmonia-тохироо, зөвшилцөл, дуурьсал) нь бүх хэсгүүд болон хэлбэрийн элементүүдийн харилцан үйлчлэл, хамт байх, бүхэл бүтэн байдлыг тэмдэглэх гоо зүйн категори юм. Энэ нэр томъёог урлаг судлал, соёлын түүх, соёл судлалд өргөн хэрэглэдэг. Хүний мэдрэхүй болон утга санаагаар баяжсан амьд дуурьсалыг сайхан гэж нэрлэдэг /93-94/.
14. Генезис (грек. genesis-үүсэл) "төрөл", "үүсэл" зэрэг үгүүдтэй утгаараа тохирох, "бүрэлдэх, буй болох болон дараач хөгжлийн үйл явцтай холбоотойг" тэмдэглэх, нийлмэл үгийн (антропогенез, культурагенез, социогенез гэх мэтчилэн) сүүлчийн бүрдүүлэгч хэсэг юм /97/.
15. География культуры (соёлын газар зүй) нь соёл орон зайд дэлгэрч тархах асуудлыг судалдаг соёл судлалын мэдлэгийн салбар, төлөвшин буй шинжлэх ухаан юм /98/.
16. Герменевтика (грек. hermeneutikos-тайлбарлан таниулах, тайлах) сэдвийг (сонгодог) тайлбарлах урлаг юм. Герменевтикийн зарчим, тэдгээрийн тайлбарлахуйн сургаал Шлейермахерийн ажлын ачаар XIX зуунд оюун ухааны тухай шинжлэх ухааны онцгой арга болсон юм. Шлейермахерийн үзэл санааг Дильтей үргэлжлүүлжээ. Тэрээр бичгээр бичиж үлдээсэн амьдралын илрэлүүдийг ойлгох урлагийг герменевтикт олж үзэж, XIX зууны сүүл, XX зууны эхэн үеийн философийн урсгалуудад ойлгохуйн (бүхэл бүтэн сэтгэл оюуны мэдрэмжээр) тухай сургаал байгалийн шинжлэх ухаан дахь "тайлбарлахуй"-гаас ялгагдахаар хүмүүнлэгийн шинжлэх ухааны арга зүйн үндэс болгосон байна /99-100/.
17. Глобальные проблемы (даяар асуудал) нь Ромын клуб анхаарал хандуулж, уг ойлголтыг томъёолсон бөгөөд орчин үеийн нийт хүн төрөлхтний өмнө тулсан асуудал юм. Даяар асуудлыг хэрхэн шийдвэрлэсэнээс хүн төрөлхтний оршин байхуйд заналхийлсэн дэлхийн халуун цөмийн дайнаас сэргийлэх, бүх ард түмний энх тайван байдлыг хангах, хөгжиж байгаа болон хөгжилтэй орнуудын хоорондох нийгэм-эдийн засгийн ан цавыг даван туулах, өлсгөлөн, ядуурал, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, хөгжиж байгаа орнуудын хүн амын түргэн өсөлтийг зохицуулах, хүрээлэн буй орчныг сүйрүүлэгч бохирдлыг зогсоох, хүн төрөлхтнийг хүнс, аж үйлдвэрийн түүхий эд,

энергийн эх сурвалж зэрэг зайлшгүй шаардлагатай нөөцөөр хангах, техникийн хувьсгалын сөрөг үр дагаварыг сэрэмжлэн зайлуулах зэрэг хүн төрөлхтний цаашдын дэвшилд хамаарах болно. Нийт хүн төрөлхтний үнэлэмжийн тэргүүлэх талыг хүлээн зөвшөөрч, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг баталгаажуулахыг даяар асуудлыг шийдвэрлэхүй шаардаж байна. Даяар асуудлын нийт хүн төрөлхтний шинж чанар хийгээд утга санаа нь тэднийг соёл судлалын судлагдахуун болгож байдаг юм /103/.

18. Государственная культурная политика (төрийн соёлын бодлого) нь үндэсний соёл болоод түүнийг бүтээгчдэд холбогдон харьцах төрийн бодлого юм /107/.

19. Гражданская культура (иргэний соёл) гэдэг нэр томъёог Г.Альмонд, С.Верба нар 1936 онд ийм нэртэй ном бичиж анх нэрлэжээ. Иргэний соёл нь нарийн нийлмэл бөгөөд зөрчилт бүхэл бүтэн байдал юм. Энэ нь хүмүүсийн амьдралын үйл ажиллагааг чанарын хувьд өөрчлөх анхны оролдлого, нийгмийн нэн чухаг хүчин зүйл болдог. Ашиг сонирхлуудын илэрхийлэл, тэдгээрийн зөвшилцөл нь иргэний соёлын чухал шинж юм. Энэ нь "приходская" соёл, "дагах, хамаарах, захирагдах соёл", "оролцох соёл" гэсэн хэв маягуудтай байна /108/.

20. Гражданское общество (иргэний нийгэм) бол төртэй харилцан үйлчлэгч, төрөөс үл хамаарах бөгөөд нийгмийн гишүүдийн хооронд хөгжингүй эдийн засаг, соёл, эрх болоод улс төрийн харилцаатай нийгэм юм. Мөн төртэй хамт эрх зүйн хөгжингүй харилцааг бүтээх, өндөр нийгэм-эдийн засаг, улс төр, соёл болон ёс суртахууны статустай иргэдийн нийгэм болно /108/.

21. Группа этническая (угсаатны бүлэг) нь социологи, соёл судлалд ашиглагддаг нэр томъёо. Угсаатны бүлэг бол гишүүд нь өөрийгөө (эсвэл өөр бусдын үзлийн үүднээс) ерөнхий соёлыг тээгч гэж ухамсарладаг нийгмийн хэсэг юм /112/.

22. Гуманизм (лат. humanus-хүний, хүнлэг) Хүмүүнлэг үзэл нь бие хүн болохын хувьд хүний үнэлэмж, түүний чөлөөтэй хөгжих эрхийг хүлээн зөвшөөрөхүй, хүний тусыг нийгмийн харилцааг үнэлэх шалгуур болгон баталгаажуулахуй юм. Харьцангуй явцуу утгаар энэ нь Эртний Грек, Ромын үеийн сайхан хийгээд хүнлэг чанарын чин эрмэлзлэлийг сэргээхийг эрмэлзэж, схоластик болон сүм хийдийн оюун санааны ноёрхлыг эсэргүүцсэн Сэргэн мандлын үеийн иргэний чөлөөт сэтгэлгээ болно /112/.

23. Гуманитарное знание (лат. humanitas-хүний уг чанар). Хүмүүнлэгийн ухааны мэдлэг нь орчин үеийн шинжлэх ухаан судлал, соёл судлалд соёлын үзэгдлийг янз бүрийн үндэслэлээр бичих, ангилалтай холбоотой соёлыг танин мэдэхүйн төвшнийг тэмдэглэхэд өргөн хэрэглэгддэг нэр томъёо юм /112/.

24. Гуманитарная культура (хүмүүнлэг соёл). Соёл судлалын судалгаанд хүмүүнлэг соёл гэдэгт философи, нийгэм судлал, хүн судлал, эрх, ёс суртахуун, урлаг, домог зүй, шашин, сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, "хүний" нийгмийн харилцаа, хүмүүнлэг боловсрол, хүмүүжил, гэгээрэл зэрэг хүмүүнлэг мэдлэгийг оруулан ойлгодог /113/.

25. Гуманность (лат. humanus- хүмүүнлэг) нь хүнлэг чанар, хүнийг хайрлан энэрэх, хүмүүст сайныг хүсэж харьцах, хүний ололт амжилтыг хүндэтгэх (хатуу харгис болоод муу, муухайг хүсэхээс ялгаатай) явдал болно /113/.

26. Деградация культуры (франц. degradation). Энэ нь соёлын (хэм хэмжээ, чин эрмэлзлэл) аль нэгэн өмнөх үеийн тогтвортой элементийг сулруулах буюу устгах, соёлын амьдралыг хялбарчлах, энгийнчлэхийг тэмдэглэх нэр томъёо /119/.

27. Дегуманизация (лат. de-тусгуурлах, устгах+ humanus-хүмүүнлэг) нь нийгмийн амьдрал дахь хүмүүнлэг, зан суртахууны болоод оюуны үнэлэмжээс татгалзах буюу түүнийг алдах, хүнийг үл хүндэлж, бие хүний шинж чанаруудыг үл тоомсорлохуй болно /119/.

28. Дезинтеграция нь тогтолцоо болох соёлын элемент хоорондын функциональ холбоог эвдэх үйл явц юм /119/.

29. Деидеологизация культуры нь үзэл сурталжуулахын эсрэг үйл. Үзэл суртлын хуучин баримтлал, дөжирсөн зүйл, хэв загвар, аливаа үзэл суртлын соёлын салбарт зохиомолоор татагдахаас татгалзах, соёлын өв, орчин үеийн соёлд, бүхэлдээ тодорхой ертөнцөд бодлогогүйгээр харьцах харилцааг илэрхийлэх нь харин үзэл суртлын оршин буй бүхялгаатай нөхцөлд хоосон бясалгал буюу ерөөс хоосон чанараас татгалзахад бус, бүр бие биенийгээ ойлгоход хүргэдэг байна /120/.

30. Деканонизация нь орчин үеийн соёлын түүх, онолд ямар нэг юм буюу хэн нэгэн хүний алдаа эндэлгүй байдалд санаархаж горьдлогоо хөгжүүлэхийг тэмдэглэх нэр томьёо /120/.

31. Деконструкция нь постконструктивизмын түлхүүр ойлголтын нэг юм. Жак Дерридагийн сургаал ёсоор деконструкци нь амьд дуу хоолой болон сэтгээлгээ гэж ойлгогдох логосыг эсэргүүцэхэд тулгуурласан сэдвийн шинжилгээний үндсэн зарчим болдог. Гуманитар соёлын сэдэвт деконструкцийг хэрэглэхэд ахуйн тулгуур ойлголтуудыг илрүүлэх зорилгоор бодит байдал болон тэмдэг (бэлгэдэл), юмс болон дүр, байгаль болон оюуны амьдрал гэх мэтсийн тухай Өрнөдийн соёлд хоёр мянга гаруй жил ноёрхсон метафизик эсэргүүцлийг даван туулахад илрэлээ олжээ /120-121/.

32. Демократическая культура (ардчилсан соёл) нь улс төр судлал, соёл судлалд ашиглагддаг нэр томьёо. Энэ нь зайлшгүй үнэлэмж, хэм хэмжээ, зан үйлийн үлгэр загварын цогц, тэрчлэн иргэдэд засаглалд идэвхи хичээлтэй, зохион байгуулалттай оролцох оролцоог хангах, түүнийг хянах явдлыг хэрэгжүүлэх улс төрийн институтуудийн үйл ажиллагаа юм /122/.

33. Деморализация (франц. demoralisation)-нь сахилга бат, оюун санааг сааруулж сулруулах, зан байдал, ерөнхий соёлын уналт аж /123/.

34. Депатриотизация (лат. de-салгах, устгах + грек. patria-эх орон). Эх орноо хайрлахаас татгалзах, эх орондоо холбогдлоо алдах, эх оронч хүмүүжлийн эсрэг чиглэсэн үзэл санааны хөдөлгөөн /123/.

35. Детерминизм культурный (лат. determinare-тодорхойлох) соёлын детерминизм нь өрнөдийн социологид өргөн дэлгэрсэн, соёлыг нийгмийн амьдралын бусад хүрээнээс хамааралгүй харцангуй автономи бүрэлдэл гэж үздэг үзэл баримтлал юм. Соёлын детерминизм ёс мэтээр нийгмийн дийлэнх гишүүд хуваалцдаг үнэлэмж болон учир холбогдол (нийгмийн суурь үзэл санаа, зарчим, итгэл үнэмшил, заншил уламжлал гэх мэт)-уудын цогц гэж үндсэндээ ойлгогддог соёлын тухай ойлголтын үлэмж өргөн тайлбарлалаар тодорхойлогддог. Өрнөдийн социологид нийгмийн хөгжил нь тэнд ноёлох шашны үнэлэмжээс хамаарна гэж баталсан М. Веберийн шашны социологийн бүтээлүүдээс соёлын детерминизм өөрийн эхлэлээ авчээ. Орчин үеийн соёлын детерминизмын төлөвшилд бас соёлын хүн судлал нөлөөлжээ. Л.Уайт, А.Кардинер, М.Мид зэрэг гол төлөөлөгчид бүдүүлэг нийгмийг заншил болон уламжлалаар зохицуулагдах соёлын тогтолцоо гэж судлажээ /123/.

36. Дефиниция культуры (лат. definition-тодорхойлолт) нь соёл судлалын утгаар үндсэн агуулга болон гол шинж тэмдгүүдийг тусгах "соёл" гэдэг ойлголтыг товч тодорхойлоход хэрэглэгддэг нэр томьёо юм. Өнөөдөр зарим социологид, соёл судлаачид соёлын тухай өвч адил (Т.Д.) тодорхойлолт байх боломжийг үгүйсгэж байхад, нөгөө хэсэг нь үгүйсгэхгүй байна. Үгүйсгэхгүй байгаа хүрээнийхэнд янз бүрийн хандлага ажиглагдаж байна. 1952 онд америкийн соёл судлаач А.Кребер, К.Клакхон нар "Соёл. Үзэл баримтлал болон тодорхойлолтын тухай шүүмжлэлт тойм" гэдэг номондоо соёлын тухай 150 орчим тодорхойлолтыг оруулжээ /124/.

37. Деятельность (үйл ажиллагаа) нь хүрээлэн буй ертөнцөд хүнээс харилцах харилцаа, түүнийг өөрчлөн байгуулах, захирахуй, хүнийг, мөн хүний нийгмийг хөгжүүлэх явц бүхий зорилго чиглэлтэй, ухаалаг, ухамсарлагдсан идэвхит чанар болно. Хүний бүтээн байгуулах үйл ажиллагаа нь байгаль, нийгмийн хуулиудтай харьцаж, тэгэхдээ байгалийнхаас ялгаатай "хоёрдогч байгаль" бүтээх нь түүний үр дүн юм /124/.

38. Деятельностная концепция анализа культуры (соёлыг шинжлэх үйл ажиллагааны үзэл баримтлал) нь аливаа соёлын өвөрмөц онцлогийг тодорхойлох хүмүүсийн амьдралын үйл ажиллагааны хэв маяг болон хэлбэрийг авч үздэг үзэл баримтлал. Хэрэв соёл нь хүн төрөлхтний биологи бус оршихуйг тэмдэглэдэг бол зэмсэг болон тэмдэг, зан үйлийн хэм хэмжээ болон дүрэм, соёлын үнэлэмж болон бэлгэдлийг хэрэглэхтэй холбоотой хүмүүсийн юмслал үйл ажиллагаа нь нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд болох нийгэм-соёлын үйл явцын өвөрмөц хэлбэр болон агуулгыг нээн илрүүлдэг /124-125/.

39. Деятельностный подход к анализу культуры (соёлыг шинжлэх үйл ажиллагааны хандлага) нь шинжлэх ухааныг амьд бөгөөд бодослог үйл ажиллагааны өвөрмөц янз байдал, тодорхой үе шат бүхий орчилт үйл явц гэж үздэг, шинжлэх ухааны хөгжлийн динамик дүр зургийг өгдөг нэг арга юм /125/.